

БАТЛАВ

ЗАХИРАЛ

Ш. БАТЖАВ

10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

Анги.....бүлэг.....

Сурагчийн нэр.....

Хугацаа 60 минут

Нийт 40 оноо

“А” ХУВИЛБАР

Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.

Лодонгийн Түдэв

Л. Түдэв эрхлэгчийг ингэж нэрлэмээр санагдаад байдаг юм. Тэрбээр ер бусын сониуч, тэмүүлэлтэй хүн. Нэг хэвэндээ улбайж суухыг огт тэвчдэггүй. Түүнийг төсөөлөөд үзвэл, өглөө бөөрөнхий байсан биетийг орой гурвалжин болгож өөрчлөхөөс нааш төдий л санаа нь амардаггүй. Цаана цаанаасаа оргилон ундрах үг, ухаан, сэтгэлгээг нь учирсан хүн болгон бишрэн гайхдаг. Зохиол бүтээлээ ч хэдэн арван янзын аргаар бичнэ. Гүн ухааны, танин мэдэхүйн, сэтгэхүйн, адал явдлын, инээдмийн эмгэнэлийн, хошин шогийн, эсээ зөгнөлийн, утга уянгын, туульс драмын гээд зөвхөн төрлийг нь тоочвол тоочиж барагдахгүй. Өөрчлөн шинэтгэгч ийм шим тэжээлийг хаанаас авдаг бол гэж гайхмаар байдаг.

Төрөлхийн бясалгалтай, мэдрэмтгийн дээр орос, англи, испани хэлээс өргөн мэдээллийг авдаг бололтой юм билээ. Түүний өмнөх ширээн дээр монголын нэр бүхий бараг бүх сонин, гадаадын олон арван сэтгүүл хэвлэл замбараа муутай нэвсийж, харин гагцхүү энэ талаараа л хайш яиш соёлгүй мэт суудаг. Гэвч хэн нэгний бичсэн материал, албан бичгийг сураглаж ороход төдөлгүй мөнөөх их новшноос суга татаад гаргаад ирнэ. Хүн уншиж болно, харин тэр бүхнийг марталгүй хадгалаад зогсохгүй дуртай үедээ гаргаж хэвлэхэд л оюунлагийн ер бусын шинж оршино. Энэ уул овоо шиг ном түүний тархийг цэнэглэнэ.

...Хэзээ ч тос гарахгүй сүүгүй үнээ шиг нөхөрт нэгэнт өөрөөр хандана. Түдэв эрхлэгчтэй анх уулзсан хүн жирийн биш ухаантай учирч байна гэдгээ хурдан ойлгож, зах замбараагүй зан араншингаа хумъж зэгийн балаа өгөх адил нөгөөх хүн аль л сонин хачин, аль л шинэ соргог зүйлийг хариу мэдээлнэ. Энэ нь түүнд элдвийг ухаж, төхөх, жижгээс том зүйл, томоос жижиг зүйл бясалгаж олоход тусалдаг биз ээ.

Түүний гишгэсэн мөрийг эргэж харвал дандаа шинэтгэж өөрчилсөн мөр байдаг . Тэр амьдралынхаа туршид гял цал өнгө төрхөө олсон газар дээр очиж байгаагүй. Хувхай сайран дээр цэцэг ургуулж өөрчилж чаддаг хүн. 50,60-аад оны залуучуудын бүтээн байгуулалтын нүргээн тасарч, зүрхний лугшилт нь нэлээд супарчихсан яах ч учраа олохoo мэдэхээ байгаад гацчихсан Монголын залуучуудын байгууллагыг хүлээж аваад огт өөр зам руу оруулсан юм. Ер нь Түдэв гуай аливаа юмыг хуучин замаас гаргаж нөгөө шинэ замд оруулахын төлөө одонд төрсөн хүн...

До. Цэнджав

1. Өгүүлбэрүүдийн төгс бус өгүүлэхүүн гишүүний илрэх байдлыг ажиглан, зөв харгалзуулаарай.

/4 оноо/

A. Тэрбээр ер бусын сониуч агаад тэмүүлэлтэй хүн.	1. Цагт нэрийн дагаврын дараа цагийн утгат угсуулан холбох угээр холбогдсон УНӨ
Б. Түүний дуу хоолой нь нэг их хүнгэнэсэн биш, нугалаа нь уран, аялгуу нь тансаг.	2. Зэрэгцүүлэн холбох угээр холбогдсон ЗНӨ
В. Хэн нэгнийг материал, албан бичиг сураглаж ороход төдөлгүй мөнөөх их новшноос суга татаад гаргаад ирнэ.	3. Хэлэх аялгаар холбогдсон ЗНӨ
Г. Тэр, хэн нэгнийг материал, албан бичгийг суралсан орж ирэх үед мөнөөх их новшноос төдөлгүй гаргаад ирнэ.	4. Цагт нэрийн дагаврын дараа өгөх оршихын –д нөхцөлөөр холбогдсон УНӨ

2. Эхэд байгаа “Түүний өмнөх ширээн дээр монголын нэр бүхий бараг бүх сонин , гадаадын олон арван сэтгүүл хэвлэл замбараа муутай нэвсийж, харин гагцхүү энэ талаараа л хайш яйш соёлгүй мэт судаг. **Гэвч** хэн нэгний бичсэн материал, албан бичгийг сураглаж ороход төдөлгүй мөнөөх их новшноос суга татаад гаргаад ирнэ.” гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийн үргийг тодорхойлж, утга ойролцоо үгээр солин найруулаарай. **\ 4 оноо **

Үүрэг:

Солин найруулсан

Нь :

3. Өгүүлбэрт онцолсон бүтээврийг ойролцоо утгатай холбох үгээр солин найруулж бичээд, холбох үгийн утгыг тайлбарлаарай. **\ 4 оноо **
“Энэ нь түүнд элдвийг ухаж, төнхөх, жижгээс том зүйл, томоос жижиг зүйл бясалгаж олоход тусалдаг биз ээ..”

Солин найруулсан

Нь:

Утгын тайлбар:

4. Дараах үгсээс алдаатай бичсэн 1 үгийг олоод, зөв болгон бичээрэй. **\ 2 оноо **
Үгс: захисан, цовхчихыг, даавралсан, хүртэлх, овгийн, ундарга

Алдаатай үг: Зөв болгосон нь:

5. “ толбо + ыг “ үгийн язгуур үндсэнд бүтээврийг залгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай.


\2 оноо

- залгасан нь:

- Дүрэм:

6. Үзсэн зохиолын хүрээнд хамгийн их таалагдсан 1 зохиолыг сонгон мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн 50-60 үгэнд багтаан бичээрэй. **\ 5 оноо **

7. Өөрийн ойр дотны болон олны танил хүмүүсээс аль нэгийг сонгон, мэдрэмж сэтгэгдэл, үнэлэмжээ илэрхийлэн, баримтад тулгуурлан хөрөг найруулал бичнэ үү. Үгийн тоо-150-180 **\10 оноо**



8.Зохиолын дараах хэсэглэл нь ямар хам сэдэв болохыг тайлбарлаарай.
/2ноо/

Аймгийн арслан Цоодолыг зүүн хөл дээр нь баруун хөлөөрөө хавсран цохингуут түүнийг зүүн гараараа хамав. Ингэж олон мэх угсралтад хийх талаараа онцгой явсан учир «Сүлжээ Насан» гэсэн нэрийг цөнгүй дуулж ирсэн билээ.

Хам сэдэв:

9. “Нэгэн залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэхүй нь зэрлэг булгын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэй, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч, зүрхийг чичруулэн догдлуулж, төв эрдэмт оюутны боловч хүслийг холбилзуулан татна. “гэсэн хэсэглэлээс зохиолчийн сонгосон өвөрмөц үг, уран дүрслэлийг ялган бичиж, утгыг тайлбарлаарай.

Уран

дүрслэл:

УТГЫН

тайлбар:

10. Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5 оноо/

نورا بھر رکھو نہ بے کم بندھو
بھسو ۶۹ بھلما چ بھسیما
بھسو بھسو مسرو دم دم
نکل ۱ بھلو دم بھسیما ۱ رکھو
بھیم نئو ۰ ۰ ملکتم بھسو
بھلو قلیم مسرو بھو یقیم دم
کھیم بھتھنگد رکھو بھس دم
نکار بھر تھم بھتھنگد رکھو
وہیم ۱ رکھو ۰

10-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**“Б” ХУВИЛБАР**

Анги.....бүлэг.....

Сурагчийн нэр.....

Хугацаа 60 минут**Нийт 40 оноо****Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.****Хүний зан араншин**

Хүний зан аашийг ойлгох маш хэцүү. Орох газар нь үл мэдэгдэх битүү ширэнгэтэй адил. Хүний зангаас араатны занг ойлгох нь хялбар. Зангаар нь хүнийг дөрвөн зэрэгт хуваана.

1-р зэрэг: Зовлон эдлэгч хүмүүс. Буруу сургаалын уршгаар биеийн зовлонд учирсан хүмүүс.

2-р зэрэг: Бусдад зовлон учруулагч хүмүүс. Амьтан алдаг, хулгай хийдэг, мөн бусад тэнэг үйлдлүүдийг хийдэг хүмүүс.

3-р зэрэг: Өөрсдийгөө зовоож, бусдад зовлон тарьдаг.

4-р зэрэг: Өөрсдөө зовдоггүй, бусдад зовлон тарьдаггүй хүмүүс.

Түүнээс гадна энэ ертөнцөд З янзын хүмүүс байна. Чулуун дээр сийлсэн бичиг шиг хүн, элсэн дээр бичсэн бичигтэй адил хүн, усан дээр бичсэн бичигтэй адил хүн байна. Чулуун дээр сийлсэн бичигтэй адил хүн бол дандаа уурладаг, уур нь гардаггүй, чулуун дээр сийлсэн мэт арилахгүй. Элсэн дээрх бичигтэй адил хүмүүс бол голдуу уурладаг, гэвч уур нь түргэн гарна. Усан дээрх бичигтэй адил хүмүүс бол бусдад муу үг хэлдэггүй, тэнэг мулгуу үг сонслоо ч хайхардаггүй, сэтгэл нь дөлгөөн тайван байдаг.

1-р хэлбэр нь. Зан араншингаар ердийн хүмүүс, түргэн зантай хөнгөндүү, тогтвортмуутай.

2-р хэлбэр нь. Занг нь ойлгоход бэрх, даруу томоотой, маш болгоомжтой, өөрийн хүслийг хянаж чаддаг.

3-р хэлбэр нь. Занг нь ойлгоход тун хэцүү буюу ойлгомжгүй. Өөрөөсөө энэ ертөнцийн шунал бүхнийг зайлцуулж чадсан.

Ийнхүү ертөнц дээр маш олон янзын хүмүүс байна. Тус бүрийнх нь занг ойлгоно гэдэг бэрх.

1. Өгүүлбэрүүдийн төгс бус өгүүлэхүүн гишүүний илрэх байдлыг ажиглан, зөв харгалзуулаарай. /4 оноо/

A. Чулуун дээр сийлсэн бичиг шиг хүн, элсэн дээр бичсэн бичигтэй адил хүн, усан дээр бичсэн бичигтэй адил хүн	I. Цагт нэрийн дагаврын дараа цагийн утгат угсруулан холбох үгээр холбогдсон УНӨ
B. Усан дээрх бичигтэй адил хүмүүс бол бусдад муу үг хэлдэггүй бөгөөд тэнэг мулгуу үг сонслоо ч хайхардаггүй	2. Зэрэгцүүлэн холбох үгээр холбогдсон ЗНӨ
V. Занг нь ойлгоход тун хэцүү буюу ойлгомжгүй.	4. Хэлэх аялгаар холбогдсон ЗНӨ
G. Орох газар нь үл мэдэгдэж эхлэх үед битүү ширэнгэтэй адил.	5. Цагт нэрийн дагаврын дараа өгөх боршихын –д нөхцөлөөр холбогдсон УНӨ

2. Чулуун дээр сийлсэн бичигтэй адил хүн бол дандаа уурладаг, уур нь гардаггүй, чулуун дээр сийлсэн мэт арилахгүй. Элсэн дээрх бичигтэй адил хүмүүс бол голдуу уурладаг, **гэвч** уур нь түргэн гарна. гэсэн өгүүлбэрийн тодруулсан үгийн үүргийг тодорхойлж, утга ойролцоо үгээр солин найруулаарай. \ 4 оноо \

Үүрэг:

Солин найруулсан
Нь :

3. Өгүүлбэрт онцолсон бүтээврийг ойролцоо утгатай **холбох үзээр** солин найруулж бичээд, холбох үгийн утгыг тайлбарлаарай. \ 4 оноо \

Занг нь ойлгоход бэрх, даруу томоотой, маш болгоомжтой, өөрийн хүслийг хянаж чаддаг.

Солин найруулсан
Нь:

Утгын тайлбар:

4. Дараах үгсээс алдаатай бичсэн 1 үгийг олоод, зөв болгон бичээрэй. \ 2 оноо \
сахисан, ууралдаг, доторх, багийн, давхарга, тоглоочихыг

Алдаатай үг: Зөв болгосон нь:


5. “ уршиг + аар “ үгийн язгуур үндсэнд бүтээврийг залгаж бичээд, дүрмийг тайлбарлаарай. \ 2 оноо \

- Залгаж бичсэн нь
- Дүрэм:

6. Үзсэн зохиолын хүрээнд хамгийн их таалагдсан 1 зохиолыг сонгон мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэн 50-60 үгэнд багтаан бичээрэй. \ 5 оноо \

.....
.....
.....
.....
.....
.....

7.Өөрийн ойр дотны болон олны танил хүмүүсээс аль нэгийг сонгон, мэдрэмж сэтгэгдэл, үнэлэмжээ илэрхийлэн, баримтад тулгуурлан хөрөг найруулал бичнэ үү.
Үгийн тоо-150-180 \10 оноо\



8. Зохиолын дараах хэсэглэл нь ямар хам сэдэв болохыг тайлбарлаарай. /20ноо/
Аймгийн арслан Цоодолыг зүүн хөл дээр нь баруун хөлөөрөө хавсран цохингуут түүнийг зүүн гараараа хамав. Ингэж олон мэх угсруулан хийх талаараа онцгой явсан учир «Сүлжээ Насан» гэсэн нэрийг цөөнгүй дуулж ирсэн билээ.

Хам сэдэв:

9. “Нэгэн залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэхүй нь зэрлэг булгын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэй, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч, зүрхийг чичруулж догдуулж, төв эрдэмт оюутны боловч хүслийг холбилзуулан татна. “Гэсэн хэсэглэлээс зохиолчийн сонгосон өвөрмөц үг, уран дүрслэлийг ялган бичиж, угтыг тайлбарлаарай.

Уран

дүрслэл:

Утгын

тайлбар:

10. Дараах эхийг үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. (5 оноо)

بَلْمَرْ بَلْسَنْ مَمْ بَلْ
بَلْشَمْ بَلْفَمْ بَلْفَوْ بَلْ بَلْ
بَلْفَوْ بَلْفَلْ بَلْفَلْ بَلْفَلْ بَلْ
بَلْفَلْ بَلْفَلْ بَلْفَلْ بَلْفَلْ بَلْ